

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжийг хот, суурин газрын дулааны сүлжээ, эх үүсвэрийн техникийн боломж, ерөнхий төлөвлөлт, техник - технологийн шинэчлэлтийн үйл ажиллагаатай уялдуулан төвлөрсөн дулаан хангамжийн системд холбоход дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох журмын зорилго оршино.

1.2.Иргэн, хуулийн этгээдээс барилга байгууламжиндаа дулааны сүлжээнд холбуулахын тулд заавал хангах иж бүрдэл техник-технологийн шаардлагыг “Техникийн нөхцөл” гэнэ.

1.3.Иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжийн зураг, төсөл боловсруулах, зураг төслийн ажлын гүйцэтгэл, барилга угсралтын ажилд хяналт тавих, барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авахад энэ журмаар олгогдсон иж бүрдэл техник-технологийн шаардлагыг мөрдлөг болгоно.

Хоёр. Техникийн нөхцөл олгох үндэслэл

2.1.Техникийн нөхцөлийг Улаанбаатар хотод 1,0 Гкал/ц, дулааны цахилгаан станцтай аймгийн төвүүдэд 0,5 Гкал/ц, бусад төвлөрсөн дулаан хангамжтай аймгийн төвүүдэд 0,25 Гкал/ц-аас дээш дулааны хэрэглээтэй шинээр баригдах барилга байгууламжид дулаан авах, ачааллыг нэмэгдүүлэх болон дулааны шугам сүлжээний горим ажиллагаанд нөлөөлөхүйц технологийн шинэчлэлт хийх тухай бүр Эрчим хүчний яам /техникийн нөхцөл олгогч/-ны техникийн нөхцөл олгох комисс /ажлын хэсэг/-ын хурлаар, дээрхи ачааллаас бага тохиолдолд тухайн орон нутгийн дулааны эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компаний холбогдох мэргэжлийн бүрэлдэхүүнтэй техникийн нөхцөл олгох комисс /ажлын хэсэг/-ын хурлаар тус тус шийдвэрлэж олгоно.

2.2. Дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох журмыг Сайдын тушаалаар баталж, Эрчим хүчний яамны техникийн нөхцөл олгох комиссын бүрэлдхүүнийг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар, орон нутгийн дулааны эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компаний техникийн нөхцөл олгох комиссын бүрэлдхүүнийг гүйцэтгэх захирлын тушаалаар тус тус томилно.

2.3.Ажлын хэсэг нь төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн захиргаа болон тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөллийг оролцуулсан бүрэлдэхүүнтэй байна

2.4.Иргэн, хуулийн этгээдийн объект нь зураг төслийн явцад дулааны ачаалал нь анхны авсан техникийн нөхцөлд заасан хүчин чадлаас 20 хувиар нэмэгдсэн тохиолдолд техникийн нөхцөлийг дахин авна.

2.5.Техникийн нөхцөлийг боловсруулахдаа харъяа дулаан дамжуулах сүлжээ болон бусад иргэн, хуулийн этгээдийн өмчлөлийн шугам, тоног төхөөрөмжөөр дамжуулан объектыг холбох тохиолдол бүрт зөвшөөрөл авч баталгаажуулсан байна.

2.6.Техникийн нөхцөл хүсэж буй иргэн, хуулийн этгээд нь дараахь материалыг бүрдүүлнэ. Үүнд:

2.6.1. Албан бичиг, өргөдөл

2.6.2.Техникийн нөхцөл олгогчоос өгсөн тодруулах хуудсын бүрдэл. /Нэгдүгээр хавсралт/

2.6.3.Тухайн нутаг дэвсгэрт зориулж гаргасан Засаг даргын “Барилгын байршил тогтоож, газар ашиглуулах эрх олгох” тухай захирамж, шийдвэр

2.6.4.Мэргэжлийн комиссын хурлын шийдвэр буюу байршлын схем

2.6.5.Архитектур төлөвлөлтийн даалгавар

2.6.6.Дулааны ачаалал, хэрэглээг тооцсон тоо хэмжээ

2.7.Ажлын хэсэг нь захиалагчаас ирүүлсэн барилга, объектын дулааны ачаалал, байршил, шугам сүлжээнд холбох хүсэлтийг газар дээр нь судалж, дулааны сүлжээний ойрын болон хэтийн төлөвлөлтийн нөхцөл байдалтай уялдуулж, төвлөрсөн дулаан хангамж бүхий хот, аймгийн төвийн хэтийн төлөв, инженерийн тооцоо судалгааг үндэслэсэн иж бүрдэл техник-технологийн дүгнэлтийг гаргана.

Гурав. Техникийн нөхцөл олголт

3.1.Техникийн нөхцөл олгогч нь нутаг дэвсгэрийн хүрээнд тухайн барилга, объектын иж бүрдэл техник-технологийн дүгнэлт, газар эзэмшүүлэх тухай аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар хэд хэдэн объектод хамтатган олгосон тохиолдолд тэдгээрийг бүхэлд нь хамарсан нэгдсэн шугам сүлжээ, дулааны төв барих боломж зэргийг үндэслэн дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөлийг олгоно.

3.2. Техникийн нөхцөл олгогч нь тухайн жилийн эхэн буюу төгсгөлд төв магистраль болон салаа шугамуудын нэвтрүүлэх чадвар, жилд олговол зохих дулааны чадлын нөөцийг тодорхойлон гаргаж, техникийн нөхцөл олгох комиссын хурлаар хэлэлцүүлэн батална.

3.3. Улаанбаатар хотод 1,0 Гкал/ц, дулааны цахилгаан станцтай аймгийн төвүүдэд 0,5 Гкал/ц, бусад төвлөрсөн дулаан хангамжтай аймгийн төвүүдэд 0,25 Гкал/ц-аас доош ачаалал бүхий дулааны техникийн нөхцөлийг төв магистраль болон салаа шугамын аль хэсэгт олгосныг сар бүр орон нутгийн дулааны эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн техникийн нөхцөл олгох комисс яамны техникийн нөхцөл олгогчид тайлагнаж байна.

3.2.Дулааны өндөр ачаалал бүхий томоохон цогцолбор объектод олгох техникийн нөхцөлийг барилга угсралтын үеийн дулааны эрчим хүчний хэрэглээг хангах түр болон объект бүрэн ашиглалтанд орсны дараахь дулааны хэрэглээг хангах байнгын гэсэн хоёр хэлбэрээр олгож болно.

3.3.Техникийн нөхцөл олгохдоо ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлийн 2002 оны 41-р тогтоолоор баталсан “Холболтын заавар”, “Төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм”, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм” болон “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”-ын шаардлагыг баримтлах бөгөөд холбогдох “Дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч”-ийн тухайн холболтын цэг дээрх чадлын хязгаар дотор техникийн нөхцөлийг олгоно.

3.4.Ажлын хэсэг нь Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлагдсан “Ажлын хэсгийн хэсгийн ажиллах журам”-ын хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

3.5.Техникийн нөхцөлийн хүчин төгөлдөр байх хугацааг объектын хүчин чадал, барилга, угсралт гүйцэтгэх ажлын тоо хэмжээнээс хамааран 1-3 жилээр тогтооно.

3.6.Дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөлийг ажлын хэсгийн ажиллах журмын дагуу баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

Дөрөв. Техникийн нөхцөлийн агуулга

4.1.Дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөлд дараахь асуудлыг тусгасан байна.Үүнд:

4.1.1.Дулааны тооцоот дээд ачаалал

4.1.2.Холболт хийх цэг(магистраль шугам, дулааны худаг, үл хөдлөх тулгуур), уг цэг дээрхи түрэлт, шугамын статик болон буцах шугамын даралт, тооцоот температур

4.1.3.Холболтын схем

4.1.4.Объектыг шинээр холбосноос болон хэрэглэгч хэрэглээгээ нэмэгдүүлсэнтэй холбогдуулан дулааны шугам, худаг, зангилаа бусад тоног төхөөрөмжүүдийн өргөтгөл хийх эсэх

4.1.5.Дулааныг хэмжих хэрэгсэл, чанарын үзүүлэлтүүдийг тогтворжуулах төхөөрөмж

4.1.6.Объектод тавигдах тусгай шаардлага

4.1.7.Объектын ашиглалт, аюулгүй ажиллагааг хангах шаардлага

4.1.8.Иргэн, хуулийн этгээд нь объектыг барих явцад дулаан авах шаардлага гарвал түр холболт хийх цэг, хугацааг тодотгосон байх

4.1.9. Орчны тохижилтыг нөхөн сэргээх талаар авах арга хэмжээ

4.1.10. Техникийн нөхцөлийн хугацаа

4.1.11. Холбогдох тогтоол, хурлын шийдвэрийн заалт

Тав. Бусад зүйл

5.1.Иргэн, хуулийн этгээд нь дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл авсан тохиолдолд суурь хураамж болох 150000 (нэг зуун тавин мянган) төгрөгийг Эрчим хүчний хөгжлийн төв Голомт банк 2105010095 тоот дансанд тушаасан байна.

5.2. Дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөлийн дагуу иргэн, хуулийн этгээдийн барьж байгуулах инженерийн байгууламж нь тохижуулсан зам талбай, ногоон байгууламжийг нэвтрэн гарах бол, тэдгээрийг нөхөн сэргээхэд гарах зардлыг шийдвэрлэж, зураг төсөлд тусгасан байна.

5.3. Төвлөрсөн дулаан хангамжийн системд техникийн нөхцөлийн дагуу иргэн, хуулийн этгээдийн тухайн объектыг холбоход ДХТ-ийн хүчин чадал, төв болон салаа шугам сүлжээг зайлшгүй өргөтгөх шаардлага гарсан үед холбогдох зардлыг хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Харин бусад иргэн, хуулийн этгээдийн өмчлөлийн ДХТ, тоног төхөөрөмжийн хүчин чадал, шугам сүлжээг өргөтгөх, нэмэгдүүлэх, холболтын схемийг өөрчлөх тохиолдолд гарах зардлыг шинээр объект холбуулж буй иргэн, хуулийн этгээд хариуцна.

5.4.Техникийн нөхцөлийг үндэслэл муутай эсвэл буруу боловсруулж олгосноос иргэн, хуулийн этгээдэд учирсан шууд хохирлыг техникийн нөхцөл олгогч хариуцна.

- 5.5. Техникийн нөхцөлийг дараахь үндэслэлээр хүчингүй болгоно. Үүнд:
- 5.5.1. Техникийн нөхцөл авахын тулд техникийн дулааны эрчим хүчний хэрэглээний өгөгдлүүдээ зориуд буруу тодорхойлсон нь тогтоогдсон бол.
- 5.5.2. Холболт хийх цэгийн хүчин чадлаас хэтрүүлэн техникийн нөхцөл олгосон бол.
- 5.5.3. Техникийн нөхцөлийн хүчинтэй байх хугацаанд тухайн объект ашиглалтанд орж, дулааны сүлжээнд холбогдоогүй бол.
- 5.6. Хугацаа дууссан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барихыг хориглоно.
- 5.7. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгуулах хүсэлтийг ажлын хэсэгт гаргана. Хугацаа дууссан техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно.
- 5.8. Техникийн нөхцөлтэй холбоотой гарсан маргааныг хууль, дүрэм, журмын дагуу шийднэ.
- 5.9. Энэхүү журмыг баталсан өдрөөс эхлэн мөрдөнө.

*Дулааны эрчим хүчээр хангах техникийн
нөхцөл олгох журмын нэгдүгээр хавсралт*

**ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН
НӨХЦӨЛ ОЛГОХ ТОДРУУЛАХ ХУУДАС**

Огноо

Дугаар

Улаанбаатар хот

1. *Техникийн нөхцөл авахаар хүсэлт гаргаж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэний нэр хаяг, утас*
2. *Техникийн нөхцөл авах объектийн байршил, хаягийн тодорхойлолт*
3. *Техникийн нөхцөл авах болсон шалтгаан*
5. *Хэрэглэгчийн зэрэглэл, ажлын горим*
6. *Цаашид өргөтгөх бол эхлэх, дуусах хугацаа, хүчин чадал (өргөтгөх бол хэзээ, ямар хүчин чадал нэмэгдэх кВт)*
7. *Орон нутгийн засаг захиргааны газар олголтын тогтоолын дугаар, огноо*
8. *Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа*

ТОДРУУЛАХ ХУУДАС БИЧСЭН (нэр)

**ДУЛААНЫ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ
КОМИСС (АЖЛЫН ХЭСЭГ)-ЫН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Комиссын эрх, үүрэг

Комисс нь дараахь эрх, үүрэгтэй байна:

- 1.1. Эрчим хүчний тухай хууль, болон холбогдох хууль, тогтоомж, норм, дүрмийн заалтын дагуу дулааны техникийн нөхцөл олгох*
- 1.2. Техникийн нөхцөл олгохтой холбогдсон баримт бичиг, магадлагааг холбогдох иргэн, хуулийн этгээдээс гаргуулан авах;*
- 1.3. Хууль тогтоомж, норм, дүрэм, стандартын шаардлага, тухайн объектод олгосон техникийн нөхцөлийн шаардлагыг зөрчсөн зураг төсөл, дутуу буюу чанаргүй гүйцэтгэсэн барилга байгууламж, шугам сүлжээний угсралт, шинэчлэл, засварын ажил илэрсэн бол зөрчил, дутагдлыг арилгуулах*
- 1.4. Техникийн нөхцөлтэй холбоотой мэдээллийг эрчим хүчний салбарын интернет веб хуудсанд байршуулан, иргэдэд ил тод нээлттэй байлгана.*

Хоёр. Хуралд бэлтгэх

- 2.1. Комиссын хурлын бэлтгэл ажлыг комиссын нарийн бичгийн дарга зохион байгуулна.*
- 2.2. Комиссын нарийн бичгийн дарга техникийн нөхцөл хүссэн баримт бичгийн бүрдлийг хянан үзэж, комиссын даргад танилцуулж, шаардлага хангасан гэж үзвэл комиссын хуралд хэлэлцүүлэх мэдээдлийг тараана.*
- 2.3. Комиссын нарийн бичгийн дарга нь хурлыг зохион байгуулан гишүүдийн ирцийг бүрдүүлэх, хурлын тэмдэглэл хөтөлж баталгаажуулах, техникийн нөхцөлийг олгох комиссын акт үйлдэх ажлыг гүйцэтгэнэ.*

Гурав. Хурлын үйл ажиллагаа

- 3.1. Комиссын гишүүдийн дөрөвний гурав буюу 75 хувийн ирц бүрдсэн тохиолдолд хурлын үйл ажиллагаа эхэлнэ.*
- 3.2. Комиссын гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй тохиолдолд комиссын хурал эхлэхээс 1 хоногийн өмнө комиссын даргад урьдчилан мэдэгдсэн байна.*
- 3.3. Комиссын гишүүд техникийн нөхцөл хүссэн өргөдөл, баримт бичигтэй танилцсаны дараа “Төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм”, “Холболтын заавар”, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм” болон “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”-ын техникийн болон бусад холбогдох дүрэм, стандартын шаардлага хангасан эсэхийг нарийвчлан шалгаж санал дүгнэлт өгнө.*
- 3.4. Гишүүд өөрийн санал, дүгнэлтээ комиссын нарийн бичгийн даргад бичгээр гаргаж өгнө.*

3.5. Комиссын дарга, гишүүдийн санал, дүгнэлтийг нэгтгэж техникийн нөхцөл олгох, эсэх асуудлыг хуралд оролцогч гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

3.6. Ашиглагч байгууллагаас оролцох комиссын гишүүн тухайн үед өөрсдийн холбоотой асуудлыг шийдвэрлэх хуралд оролцоно.

Дөрөв. Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх

4.1. Комиссын гаргасан шийдвэрийг үндэслэн олгосон техникийн нөхцөлд комиссын дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гарын үсэг зурж албажуулна.

Дулааны техникийн нөхцөл олгох комиссын бүрэлдэхүүн

Дулааны техникийн нөхцөл олгох комисс дараахь бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

<i>Комиссын дарга:</i>	<i>Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар</i>
<i>Орлогч дарга</i>	<i>Эрчим хөгжлийн төвийн дэд захирал</i>
<i>Нарийн бичгийн дарга:</i>	<i>Эрчим хүчний хөгжлийн төвийн техникийн нөхцөл хариуцсан мэргэжилтэн</i>
<i>Гишүүд:</i>	<i>Эрчим хүчний хэлтсийн дулааны ахлах мэргэжилтэн</i>
	<i>Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын төвлөрсөн дулаан хангамж хариуцсан мэргэжилтэн</i>
	<i>Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын бүс нутгийн дулаан хангамж хариуцсан мэргэжилтэн</i>
	<i>Хуулийн хэлтсийн төлөөлөл</i>
	<i>Эрчим хүчний хөгжлийн төвийн төлөөлөл</i>
	<i>Тухайн орон нутгийн дулаан хангамжийн системийн Тусгай зөвшөөрөл эзэмшигч эх үүсвэр, шугам сүлжээний ерөнхий инженерүүд</i>